

БШУ Сайд, ЭМ Сайдын хамтарсан тушаалын ерөнхий мэдээлэл

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ нь 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан бөгөөд тус тушаалд “КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ҮЕД ЦЭЦЭРЛЭГИЙН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ТҮР ЖУРАМ, КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ҮЕД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ТҮР ЖУРАМ-ыг батлан гаргасан болно. Тушаалтай [ЭНД](#) дарж танилцана уу.

Тус тушаалын дагуу системд тулгуурлан хийгдэх бүртгэл:

- АУБ нь Суралцагчдаас суралцах хэлбэр /танхим, зайн, хосолсон/-ийн асуулга авах, нэгтгэх
- Эцэг, эхээс чөлөөний хүсэлтийг системээр хүлээн авах
- Сурагчийн үнэмлэх олгох /QR код бүхий/
- Сургууль, цэцэрлэгт нэвтрэх бүртгэл
- Багш, Ажилтан, Суралцагч бүгд QR код бүхий үнэмлэхтэй байна
- Гар утасны аппликэйшн, Вэб систем ашиглаж болно
- Эрүүл мэндийн асуумжыг эцэг, эх болон багш бөглөх
- Хариу арга хэмжээний бүртгэл
- Нэгтгэл тайлан нь яам болон тандалтын багын ажилтанд харагдана
- Ирц, Өвчлөл, Авсан арга хэмжээ гэх мэт

Жишээ нь:

Өдрийн ирц, тандалт бүртгэлийн үйл явцыг хураангуйлан харуулав.


Сэлэнгэ аймгийн Мандал сумын
Хэрх тосгоны ерөнхий
боловсролын сургууль



Анги: 1а
Овог: Оргилтулга
Нэр: Баясгалан
Утас: _____

parent.edu.mn || medle.mn

Сурагчийг сургуульруу нэвтэрхэд тандалтын баг нь дараах дарааллын дагуу бүртгэлийг хийнэ.



QR кодгүй, суралцагчийн үнэмлэхээ мартсан суралцагчийн мэдээллийг гараас оруулах боломжтой.



The application interface shows a list of students on the left and a detailed entry form on the right. The form includes fields for name, age, and gender, and buttons for 'Хэвийн' (Normal) and 'Сэжигтэй' (Abnormal). The right side of the form features a grid of health status indicators with radio buttons, such as 'Ханиалгаж байгаа эсэх' (Coughing) and 'Ядарч байгаа эсэх' (Tired). A 'Хадгалах' (Save) button is at the bottom.

Өдрийн ирцийн нэгтгэлийг:

- Тухайн сургууль

- Аймаг, дүүргийн БХ, НБГ, БСУГ

- Улсын хэмжээнд БШУЯ суралцагчийн суралцах хэлбэрээс үл хамааран ирцийн мэдээллийг нэгтгэн харах боломжтой.

Тандалтын баг болон Анги удирдсан багш нар esis.edu.mn вэб болон ESIS аппликэйшн ашиглан тухайн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн дэлгэрэнгүй мэдээллийг харж ар гэрт нь мэдээллэх боломжтой. Тус мэдээлэлд:

- Эцэг эхийн утасны дугаар
- Гэрийн хаяг
- Имэйл хаяг зэрэг багтана.